



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 28

Мөрөн

┌ Төр сүм хийдийн харилцааг зохицуулах ┐
зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хөвсгөл аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих зөвлөлийг хавсралтаар баталсугай.

2. Шашны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах журмыг хэрэгжүүлж, үр дүнг 2 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулж ажиллахыг зөвлөлд даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Гончиг)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 27 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

113160056

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын
13-ны өдрийн 28 дугаар тогтоолын хавсралт



ТӨР СУМ ХИЙДИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

Дарга: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд: Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Соёлын хяналтын улсын байцаагч

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл, спортын бодлого харицусан мэргэжилтэн

Аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн, Хүүхдийн эрхийн улсын байцаагч

Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын Соёлын өв хариуцсан мэргэжилтэн

Тагнуулын Ерөнхий газрын Хөвсгөл аймаг дахь Тагнуулын хэлтэс

Гадаадын иргэн харъяатын газрын хойд бүс дэх газрын Хөвсгөл аймаг дахь салбар

Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасаг